



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/367

Арвайхээр

Арвайхээр сумын Цэцэрлэг, бага сургуулийн цогцолборын бүтэц, хэв шинжийг өөрчилж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болгон өөрчлөн байгуулах тухай


Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын дүгнэлтийг үндэслэн Арвайхээр сумын Цэцэрлэг бага сургуулийн цогцолборын бүтэц, хэв шинжийг өөрчилж, Арвайхээр сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Тэмүүлэл” сургууль, Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэг болгон өөрчлөн байгуулсугай.

2. Өөрчлөн байгуулагдсан Арвайхээр сумын математик, гадаад хэлний гүнзгийрүүлсэн, урлагийн төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Тэмүүлэл” сургууль, Арвайхээр сумын 13 дугаар цэцэрлэгийн бүтэц, зохион байгуулалтыг хийх, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т, холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгэхийг Улсын бүртгэлийн хэлтэс (А.Мөнхтөр) нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Сургалтын ажил эрхлэх урьдчилсан зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх тухай 2009 оны 02 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100592